



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТӨГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалтыг тус тус үндэслэн ТӨГТООХ нь:

Нэг. “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, батлагдсан төсвийг хуваарилах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах нарийвчилсан заавар, нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны зарим төрлийн зардлын норм, норматив тогтоон мөрдөж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт) -т үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.



Нийгмийн даатгалын үндэсний  
зөвлөлийн 2021 оны 27 дугаар  
сарын 21 нийт өдрийн 10 дугаар  
тогтоолын хавсралт

1119276367  
5284706 111-473

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ,  
ТӨСӨӨЛӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАТЛАГДСАН ТӨСВИЙГ  
ХУВААРИЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийг Төсвийн тухай, Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, батлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөл /цаашид “төсвийн төсөл, төсөөлөл” гэх/-ийг боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өргөн мэдүүлэх, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, батлагдсан төсвийн аймаг (нийслэл), сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудын болон сар, улирлын хуваарь /цаашид “төсвийн хуваарь” гэх/-ийг боловсруулах, батлах, төсвийн хуваарыт өөрчлөлт оруулах, хүргүүлэхэд энэ журам /цаашид “журам” гэх/-ыг баримтална.

1.3. Журмын хэрэгжилтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар зохион байгуулна.

1.4. Журмын хэрэгжилтэд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нар хяналт тавьж ажиллана.

Хоёр. Төсвийн төсөл, төсвийн хуваарь боловсруулахад  
баримтлах зарчим, тавигдах шаардлага

2.1 Төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хуваарийг боловсруулахад Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

2.1.1 Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр бүрэн нөхдөг байх;


2.1.2 Өмнөх 3 жилийн төсвийн гүйцэтгэлд суурилсан байх;

2.1.3 Хүрсэн түвшингээс үндэслэлгүйгээр бууруулахгүй байх, буурах тохиолдолд үндэслэл, шалтгаан нь нотлогдсон байх;

2.1.4 Үр ашиггүй зардлыг багасгах, төсвийн хэмнэлтийн горимыг баримталсан байх;

2.1.5 Төсвийн төсөл боловсруулахад төсвийн удирдамжийг баримтлах.

2.2 Төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хуваарь нь дараах шаардлагыг хангасан байна:



2.2.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийг сан тус бүрээр, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг эдийн засгийн ангиллаар;

2.2.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийн үзүүлэлт нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагаад бүрэн нийцсэн үнэн зөв, үзүүлэлт **Хоорондын** уялдааг хангасан байх;

2.2.3 Төсвийн тэнцэл алдагдалгүй байх зарчмыг баримтлах бөгөөд алдагдалтай тохиолдолд алдагдлыг хэрхэн шийдвэрлэх саналыг тусгасан байх.

2.3 Төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулахдаа нийгмийн даатгалын байгууллагуудаас ирүүлсэн санал, сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжилтийн эх үүсвэртэй нь уялдуулан сар, улирлын онцлогийг харгалзан боловсруулна.

Гурав. Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах удирдамж

3.1 Нийгмийн даатгалын ерөнхий газар нь төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах удирдамжийг аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудад 6 дугаар сарын 5-ны дотор хүргүүлнэ. Уг удирдамжид Төсвийн тухай хуулийн 27.4-т зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

3.1.1. Тухайн жилд эрх бүхий байгууллагаас тогтоосон зардлын норм, нормативуудын өөрчлөлт;

3.1.2. Тухайн жилд гарсан болон дараа жил хэрэгжүүлэхээр батлагдсан бодлогын өөрчлөлтийн шийдвэрүүд.

Дөрөв. Төсвийн цаглабар

4.1 Төсвийн төслийг дараах цаглабарын дагуу боловсруулна:

4.1.1. Сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь төсвийн төсөл, төсөөллийг жил бүрийн 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх;

4.1.2. Аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;

4.1.3. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь төсвийн төсөл, төсөөллийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Төсвийн тухай хуулийн 8.4.2-т заасан хугацаанд нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

4.2. Төсвийн сар, улирлын хуваарийг дараах цаглабарын дагуу боловсруулж батална:

4.2.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь төсвийн хуваарийн саналыг Төсвийн тухай хуулийн 8.6.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

4.2.2. Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн хуваарийн саналаа Төсвийн тухай хуулийн 8.6.2-т заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад

хүргүүлэх.

4.3. Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах нарийвчилсан зааврыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга батална.

1116125031. 5284708

Тав. Нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүрэг

#### 5.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь дараах үүрэгтэй:

5.1.1. Аймаг (нийслэл), сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагыг төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахтай холбоотой нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах;

5.1.2. Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, нэгтгэх, төсвийн төсөлтэй холбоотой баримт бүрдүүлэх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах;

5.1.3. Аймаг (нийслэл), дүүргийн төсвийн хуваарийг боловсруулах, төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулах, батлах, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулах.

#### 5.2. Аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нар дараах үүрэгтэй:

5.2.1. Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, хяналт тавих, нэгтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах;

5.2.2. Төсвийн төсөл, төсөөллийн саналыг хэлтсийн даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн сар, улирлын хуваарыт өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт хүргүүлэх;

5.2.3. Дүүргийн орлого, шимтгэлийн байцаагчийн орлогын төлөвлөгөө, сумын нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн жилийн болон сар, улирлын хуваарийг батлах;

5.2.4. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих.

#### 5.3. Аймаг (нийслэл), сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудын санхүү, төсвийн төлөвлөлт хариуцсан ажилтан дараах үүрэгтэй:

5.3.1 Төсвийн төсөл, төсөөллийн саналыг нэгтгэх, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн сар, улирлын хуваарыт өөрчлөлт оруулах саналыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулж тайлбар, танилцуулга, холбогдох баримт нотолгоог хавсаргах;

5.3.2 Дүүргийн орлого, шимтгэлийн байцаагчийн орлогын төлөвлөгөө, сумын нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн жилийн болон сар, улирлын хуваарийг боловсруулах;

5.3.3 Нийгмийн даатгалын ерөнхий газраас шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж хүргүүлэх.

Зургаа. Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах

6.1. Аймаг (нийслэл), сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын энэ журмын 5.2.1-д заасан ажлын хэсэг нь, төсвийн төсөл, төсөөллийг боловсруулан хянан нэгтгэж, хэлэлцэнэ. Сумын нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ нь аймгийн нийгмийн даатгалын байгууллагад, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь Нийслэлийн нийгмийн даатгалын газарт, аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газарт энэ журмын дөрөвдүгээр зүйлд заасан хугацаанд тус тус хүргүүлнэ.

6.2. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь:

6.2.1. Аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудаас энэ журмын 3.1-6 заасан удирдамжийн дагуу боловсруулсан төсвийн төсөл, төсөөллийн саналын иж бүрэн байдал болон холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянан хуульд заасан хугацаанд хүлээн авч, шаардлагад нийцээгүй төслийн саналыг холбогдох нийгмийн даатгалын байгууллагад буцаан саналыг дахин авна.

6.2.2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар нь төсвийн төсөл, төсөөллийн саналыг хянан, нэгтгэн боловсруулж, нэгдсэн саналыг танилцуулгын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын Зөвлөлийн хурлаар, Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр тус тус хэлэлцүүлнэ.

6.2.3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс гарсан саналыг төсөлд тусган тайлбар, танилцуулгын хамт Төсвийн тухай хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Долоо. Төсвийн хуваарь болон төсвийн сар, улирлын хуваарь батлах, хүргүүлэх

7.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Улсын Их Хурлаар баталсан Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг үндэслэн аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудаас ирүүлсэн санал, нийгмийн даатгалын сангийн сар, улирлын мэдээ, улирал, жилийн санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиглэл, зөвлөмжийн дагуу аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудын төсвийн хуваарийг боловсруулан батлуулахаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлнэ.

7.2. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудын төсвийн хуваарийг хэлэлцэн баталж, тогтоол гаргана.

7.3. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь энэ журмын 7.2-т зааснаар баталсан төсвийн хуваарийг үндэслэн аймаг (нийслэл), дүүргийн төсвийн сар, улирлын хуваарийн саналыг боловсруулан Төсвийн тухай хуулийн 8.6.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.4. Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 7.3-т заасны дагуу ирүүлсэн саналыг хянан Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.5. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь нийгмийн даатгалын сангийн төсвийн сар, улирлын хуваарийг батална.

7.6. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга нь аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудын төсвийн сар, улирлын хуваарийг баталж, хүргүүлнэ.

7.7. Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нь сумын нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн жилийн болон сар, улирлын хуваарийг баталж хэрэгжилтэд хяналт тавина.

7.8. Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нь дүүргийн орлого, шимтгэлийн байцаагчийн орлогын төлөвлөгөөний жилийн болон сар, улирлын хуваарийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

#### Найм. Төсвийн хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулах

8.1. Аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах саналаа үндэслэл, тайлбар, холбогдох баримт бичгийн хамт хавсарган Нийгмийн даатгалын ерөнхий газарт тухай бүр ирүүлнэ.

8.2. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг хянан нэгтгэж, саналыг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан нийгмийн даатгалын сангийн төсвийн сар, улирлын хуваарийн өөрчлөлтийг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга аймаг, (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудын төсвийн сар, улирлын хуваарийг өөрчлөн баталж холбогдох аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавина.

8.4. Төсвийн тухай хуулийн 34.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудаас ирүүлсэн төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тусган энэ журмын 5 дугаар зүйлд заасан баримтлах зарчим, тавигдах шаардлагын дагуу санал боловсруулж нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.5. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан төсвийн нэмэлт, өөрчлөлтийн аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудын хуваарийг энэ журамд заасны дагуу боловсруулж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулна.

8.6. Нэмэлт, өөрчлөлт орсон төсвийн сар, улирлын хуваарийг энэ журмын 7 дугаар зүйлд заасныг баримтлан баталж, хүргүүлнэ.

#### Ес. Хариуцлага

9.1. Энэ журмыг зөрчсөн буруутай албан тушаалтанд Төсвийн тухай хуулийн 70.4.1-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.